



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 4/17

Улаанбаатар хот

Сургалтын үйл ажиллагаанд
зохицуулалт хийх тухай

Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.8, 13 дугаар зүйлийн 13.2.1, 13.2.6, 13.2.7 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны шийдвэр, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/11 дүгээр тушаал, МУИС-ийн дүрмийн 4.3.1, 4.3.8.4, дэх хэсэг, МУИС-ийн Захиргааны зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хурлын тэмдэглэл, шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. 2020-2021 оны хичээлийн жилийн хаврын улирлын өндөржүүлсэн бэлэн байдлын үед сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх удирдамжийг хавсралтаар баталсугай.

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэглэл өөрчлөгдсөн үед удирдамжид өөрчлөлт оруулж, Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг Сургалт, оюутан хариуцсан дэд захирал /Д.Бадмаанямбуу/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутан хариуцсан дэд захирал /Д.Бадмаанямбуу/, Захиргаа, хүний нөөцийн газрын дарга /Г.Мөнхбаяр/, Мэдээллийн технологийн газрын дарга /А.Баатарбилэг/, бүрэлдэхүүн сургуулийн захирал /Д.Заяабаатар, Д.Бямбажав, Ж.Эрдэнэбулган, Ч.Энхбаяр, С.Баттулга, Н.Баатарбилэг/, салбар сургуулийн захирал /Г.Энх-Амгалан, Д.Алтанхуяг/ нарт тус тус үүрэг болгосугай.


ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ОЧИРХУЯГ

3340500121

Захирлын 2021 оны ... дүгээр сарын ... -ны
өдрийн ... дугаар тушаалын хавсралт



СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХ УДИРДАМЖ

НЭГ. Сургалтын үйл ажиллагаатай холбоотой зохицуулалт

Сургалтын үйл ажиллагаа

1.1 Хаврын улирлын сургалтын үйл ажиллагааг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэглэл өөрчлөгдөх хүртэл сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу цахим хэлбэрээр зохион байгуулна.

1.2 Microsoft Teams платформыг сургалтын үндсэн платформ болгон ашиглаж, хичээлийг дараах 2 хэлбэрээр зохион байгуулна. Үүнд:

А. Хичээлийн хуваарьт цагт шууд цахим /синхрон/-аар хичээл орж, хичээлийн бичлэгийг платформд байршуулах

Б. Хичээлийн хуваарьт цагт урьдчилан бэлтгэсэн видео агуулгыг платформд байршуулж хичээлийн дараагийн оролт хүртэл хэлэлцүүлэг хийх

1.3 Online.num.edu.mn (Open EdX) сургалт удирдлагын системд бүртгүүлсэн цахим хичээлийг тухайн платформоор орж болно. Энэ тохиолдолд Microsoft Teams платформ ашиглахыг шаардахгүй.

1.4 Лекц, семинар, лабораторийн хичээлийн материалыг хичээлийн улирал дуустал платформд байршуулна.

1.5 Хуваарьт цагт тухайн хичээл орж буй эсэхийг хичээлийн группт орсон Элсэлт, бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн хяналт тавина.

1.6 Хичээлд хамаарах даалгавар нь цахимаар олох боломжтой материал, ном, сурах бичгийн хүрээнд байна.


1.7 Цахим сургалтын чанар хангалтгүй гэж үзвэл холбогдох арга хэмжээ авна.

Дүнгийн гомдол, маргаан:

1.8 Дүнгийн маргаан, гомдлын өргөдлийг 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл хүлээн авна. Суралцагч дүнгийн гомдол маргааны өргөдлийн маягтыг бөглөн багшид цахимаар илгээх ба багш маягтыг баталгаажуулан багшийн ажлын дэвтэр, шалгалтын хуудас гэх мэт холбогдох материалын хамт Элсэлт, бүртгэлийн хэлтсийн бүртгэл хариуцсан мэргэжилтэнд өгч шийдвэрлүүлнэ.

I, E үнэлгээтэй хичээл:

1.9 Өмнөх улиралд бүрэн дүгнэгдээгүй I, E үнэлгээтэй хичээлийн нөхөн шалгалтыг 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрүүдэд багш цахимаар зохион байгуулж, үнэлгээг системд оруулна.



ХОЁР. Суралцагч хичээл сонгох, баталгаажуулах, цуцлахтай холбоотой зохицуулалт

2.1 Суралцагч сонгосон багц цагийн төлбөрийн 50-аас доошгүй хувийг төлж хичээл баталгаажуулалт хийнэ.

2.2 Хичээл баталгаажуулалтыг хичээл сонгосноос хойш 72 цагийн дотор хийнэ.

2.3 Цахим сургалтын чанарын явцын санал асуулгыг сургалтын 3-4 дэх долоо хоногт зохион байгуулж, тухайн хичээлийг сонгосон идэвхитэй суралцагчдын олонхи нь цахим сургалтын чанар хангалтгүй гэж үзвэл тухайн хичээлийг цуцална. Хичээл цуцалсан тохиолдолд суралцагчийн тухайн хичээлийн багц цагийн төлбөрийг бүрэн буцаан олгоно. Суралцагч тухайн хичээлийг зааж байгаа өөр багшийн хичээлд шилжин суралцаж болно. Цуцлагдсан хичээл заасан багшид тухайн хичээлийн А цагийн ноогдол олгохгүй.

2.4 Суралцагч үлдэгдэл төлбөрийг 2021 оны 04 дүгээр сарын 01-ээс өмнө төлж барагдуулна. Хэрэв дурдсан хугацаанд сургалтын төлбөр төлж барагдуулахгүй бол хичээлийг цуцална.

ГУРАВ. Танилцах, мэргэжих, хээрийн, үйлдвэрлэлийн болон багшлах дадлага, лабораторийн хичээлийн зохицуулалт

3.1 Танилцах, мэргэжих, хээрийн, үйлдвэрлэлийн болон багшлах дадлагуудыг холбогдох газруудад цахим хэлбэрээр хийж дуусгахаар зохион байгуулна.

3.2 Дадлагын хамгаалалтыг цахим хэлбэрээр зохион байгуулна.

3.3 Лабораторийн хичээлийг агуулгын хүрээнд багтаан лабораторийн зөвлөгөө, бататгах дасгал бүхий видео эсхүл семинарын хичээл хэлбэрээр зохион байгуулна.

ДӨРӨВ. Бусад

4.1. Бусад асуудлыг холбогдох дүрэм, журмын дагуу зохицуулна.